

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН 2021-2022 ОНЫ ХАМТ /ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжид
нийцэж байгаа тул 2021 оны 7 сарын 1...-ний өдөр бүртгэв.

Улаанбаатар хот
2021 он



ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН 2021-2022 ОНЫ ХАМТ /ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭЭР

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, “Хөдөлмөрийн тухай” хуулийн II дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.5, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.5, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь заалт, Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ОУХБ-н 176-р конвенцыг тус тус үндэслэн энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээрийг байгуулж байна.


Хэлэлцээрийн зорилго нь: Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын /цаашид салбарын гэх/ хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэх, үйлдвэрлэлийн үр ашиг, салбарын тогтвортой байдлыг хангахад оршино.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын өмчийн хэлбэр харгалзахгүй аж ахуйн нэгж, байгууллагууд хамтын гэрээ байгуулан харьяа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлэн мөрдөж ажиллана. Хэлэлцээрийн биелэлт, явц, үр дүнд хэлэлцээр байгуулагч талууд хамтран хяналт тавина.
- 1.2 Хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэх эдийн засгийн үндэс нь ажил олгогчдын санхүүгийн чадавх болох тул салбарын аж ахуйн нэгжүүдийн орлого, ашгаа нэмэгдүүлэхэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, салбарын агентлагауд, Монголын Эрчим Хүч, Геологи, Уул уурхайн ҮЭ-ийн холбоо, мэргэжлийн холбоод хуулийн хүрээнд бодлого, шийдвэрээрээ дэмжинэ.
- 1.3 Салбарын аж ахуйн нэгж байгууллага бүр энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн өмнөх хүрсэн түвшинг бууруулахгүй байхыг эрмэлзэж хамтын гэрээг байгуулж ажиллана.

Хоёр. Хөдөлмөрийн харилцааны талаар

- 2.1 Ажилтнуудыг бөөнөөр халах, хөдөлмөрлөх нөхцөл байдлыг дордуулахад нөхцөл байдал үүссэн тохиолдолд аж ахуй нэгж, байгууллага /ажил олгогч/ нь 45 хоногийн өмнө холбогдох үйлдвэрчний эвлэлийн байгууллагад урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хангах, нийгмийн хамгааллын талаар тусгай гэрээ байгуулж, орон нутгийн хөдөлмөр зохицуулалтын албандаа бичгээр мэдэгдэнэ. Ажил олгогч ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ажилтны хууль ёсны эрхийг хамгаалах байгууллага болох ҮЭ-ийн хороонд албан ёсоор мэдэгдэнэ.



- 2.2 Монгол улсын хуулийн дагуу салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг өөрчлөн зохион байгуулах, хувьчлах тохиолдолд ажилтнууд болон өндөр насны тэтгэвэрт гарсан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас групп тогтоолгосон ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг эрх залгамжилж авсан хуулийн этгээд хариуцна.
- 2.3 Төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал хариуцаж байсан болон салбарын аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан хугацааг тус салбарт ажилласанд тооцно. /Орон тооны ҮЭ-ийн хороодын дарга наарт нэг адил хамаарна/
- 2.4 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг тэдний мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг ашиглах зорилгоор өөрийнх нь эрүүл мэндэд харшлахгүй ажлын байраар хангах талаар ажил олгогч санаачлага гаргаж болно.
- 2.5 Байгууллагад ажиллаж байгаад цэргийн албандаа татагдан хугацаат цэргийн алба хаасан ажилтныг өөрийн хүсэлтийг үндэслэн ажлын байраар хангаж болно.
- 2.6 Хөдөлмөрийн тухай хуулийн 79.6-д зааснаар салбарын ажилтны нэмэгдэл амралтыг тухайн ажилтны ажилласан жилийг харгалзан үндсэн амралт дээр нэмж олгох асуудлыг хамтын гэрээнд тусган шийдвэрлэнэ.
- 2.7 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар хөгжих хууль эрх зүй, бизнесийн орчныг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.
- 2.8 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компани, аж ахуйн нэгжүүдийн ажлын байрны мэдээллийн нэгдсэн сантай болох ажлыг хамтран зохион байгуулна.
- 2.9 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт шинэ технологи, инноваци нэвтрүүлэх замаар Монгол улсад өндөр технологийн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, энэ салбарт хөдөлмөр эрхлэлтийн хэмжээг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллах бөгөөд ажиллагсдын эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэхэд талууд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 2.10 Хөрөнгө оруулалт технологийн өндөр шалгууртай уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн компани, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчлах, дэмжих, борлуулалтын зах зээлийг хамгаалах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр тодорхой ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.
- 2.11 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг “Эх оронч” худалдан авалтаар дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар ажлын байрыг өргөжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.
- 2.12 Аж ахуйн нэгж бүр Хөдөлмөрийн тухай хуулийн 111 – р заалтыг хэрэгжүүлж ажиллуулна.
- 2.13 Аж ахуйн нэгж бүр “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” – ыг мөрдөн ажиллана.



Гурав. Цалин хөлсний талаар

- 3.1 Цалин хөлсийг инфляцын түвшин, үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж, хэрэглээний ба үйлдвэрлэлийн үнэ, тарифын өсөлт зэргийг харгалзан үндсэн цалинг нэмэгдүүлэх асуудлыг аж ахуйн нэгж байгууллагууд хамтын гэрээгээр хамтарч зохицуулна. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны улсын хэлэлцээр, цалин хөлсний бодлогын хүрээнд өмнөх жилийн инфляфийн түвшингээс бууруулахгүйгээр ажилтнуудын үндсэн цалинг нэмэгдүүлнэ.
- 3.2 Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.
- 3.3 Ажилтанд хөдөлмөрийн цалин хөлсийг сард хоёр удаа тогтоосон хугацаанд олгоно.
- 3.4 Ажил мэргэжил хавсран, хослон, орлон ажилласны нэмэгдлийг хавсран, хослон, орлон ажилласан албан тушаалын цалингийн 40 хувиар бодож олгоно.
- 3.5 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголын Эрчим Хүч, Геологи, Уул уурхайн ҮЭ-ийн холбооноос хамтран олгож байгаа "Тэргүүний мастер" цол тэмдгийн дагалдах мөнгөн шагнал 100,000 төгрөгийг тухайн байгууллага олгоно.
- 3.6 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлээгүй бол сул зогсолтын олговор нь уг ажилтны үндсэн цалингийн 60 хувиас доошгүй байна.
- 3.7 Тасралтгүй ажиллагаатай аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудад олгох шөнийн цагийн нэмэгдлийг хамтын гэрээгээр тохиролцон тогтооно.
- 3.8 Байгууллагын жилийн ажлын үр дүнг харгалзан жилд нэг удаа үндсэн цалингаар тооцож 6 хүртэл сарын цалинтай тэнцэх жилийн үр дүнгийн урамшуулал олгох асуудлыг хамтын гэрээгээр тохиролцон зохицуулна.
- 3.9 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар өндөр ур чадвар гарган ажиллаж байгаа ажилтанд олгох ур чадварын нэмэгдлийг хамтын гэрээгээр шийдвэрлэнэ.
- 3.10 Сарын ажиллагааны үр дүнгийн шагналын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 3.11 Оновчтой санал, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх замаар зардал хэмнэсэн тохиолдолд олгох шагналын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 3.12 Салбарт тасралтгүй ажиллаж байгаа ажилтанд удаан жил ажилласны нэмэгдлийг ажилласан хугацаанаас хамааруулан үндсэн цалингийн 40 хүртэл хувиар бодож хамтын гэрээгээр зохицуулна.
- 3.13 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад нөхцөлийн нэмэгдлийг хамтын гэрээгээр зохицуулна.

Дөрөв. Ажилтнуудын мэргэжил, боловсролын талаар

- 4.1 Захиргаа нь Үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас зохион байгуулж байгаа сургалт, семинар болон бусад үйл ажиллагаанд ажилтнуудыг хамруулах бололцоогоор хангана.



- 4.2 Ажил олгогч нь ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.
- 4.3 Салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулж, шинэ арга барил, ажлын туршлага, мэдээлэл солилцуулах арга хэмжээ авна.
- 4.4 Иргэнийг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр дагалдангаар ажиллуулах тохиолдолд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүйгээр цалинжуулна.
- 4.5 Салбарын хэмжээнд хийгдэж байгаа техник, технологийн шинэчлэлт, хүний нөөцийн бодлогын дагуу ажилтнуудын мэргэжил, боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад ажил олгогчийн санаачлагаар суралцсан ажилтанд сургалтын хугацаанд албан тушаалын сарын цалинг олгоно.
- 4.6 Салбарын улсын зөвлөгөөнийг 2 жил тутамд талууд хамтран зохион байгуулна.

Тав. Нийгмийн асуудлын талаар

- 5.1 Ажилтнуудад хоол, унааны хөнгөлөлтийг хамтын гэрээгээр тохиролцон олгоно.
- 5.2 Төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй сууцанд амьдардаг ажилтанд тухайн жилийн бэлтгэлийн үнээр бодож жилд 1 удаа 3 тн сайжруулсан түлш болон 4м³ модыг 50 хувь хөнгөлж олгоно. /Энэ заалт ахмадууд YО, МШӨ-ний групптэй хүмүүст нэг адил хамаарна./
- 5.3 Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үүднээс рашаан сувилалд сувилуулсны зардлыг магадлан итгэмжлэгдсэн рашаан сувиллын илгээх бичгийг үндэслэн жилд 1 удаа 50 хувиар хөнгөлнө. /Энэ заалт ахмадууд YО, МШӨ-ний групптэй хүмүүст нэг адил хамаарна./
- 5.4 Салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтанд салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.
- 5.5 Салбарын тэмдэглэлт ойг тохиолдуулан “Ажилтнуудын урлаг, спортын наадам”-ыг талууд хамтран зохион байгуулна.
- 5.6 Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлд өртөж орон гэргүй болсон, эд хөрөнгийн хохирол учирсан ажилтанд хохирлын хэмжээг харгалзан үзэж нэг удаагийн буцалтгүй тусламжийг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.7 Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.1, 97.1.2 дугаар заалтын дагуу нөхөн төлбөр дахин олгох тохиолдолд эдийн засгийн боломждоо тулгуурлан тухайн YЭ-ийн хороотой зөвшилцэн хэрэгжүүлнэ.
- 5.8 Байгууллагын хөдөлмөрийн аварга, хүндэт дэвтэрт бичигдсэн ажилтан, ажил мэргэжлийн аваргыг шагнах шагналын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.9 Салбарын тэргүүний ажилтны нэмэгдэл урамшууллыг сар бүр 10.000 төгрөгөөс доошгүйгээр тогтоож тус салбарт ажиллаж байгаа бусад салбарын тэргүүний ажилтан, гавьяат ажилтан, төрийн шагналтан, хөдөлмөрийн баатарт олгох нэмэгдэл урамшууллын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.10 Монгол Улсын төрийн дээд шагнал Төрийн соёрхолт, Гавьяат ажилтан, Хөдөлмөрийн баатар/-аар шагнагдсан салбарын ажилтан, өндөр настанд тухайн ажиллаж байгаа болон харьяалагдах байгууллагаас нэг удаагийн мөнгөн урамшуулалт олгох асуудлыг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.



- 5.11 Ажилтны эцэг эх, эхнэр нөхөр, хүүхэд нас барж уй гашуу тохиолдоход үзүүлэх мөнгөн тусlamжийн хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.12 Ажилтан болон ахмадуудаас ирсэн өргөдлийг үндэслэн тухайн өрхийн нэг хүнд ногдох орлого нь амьжирагааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй, З хүртэл насын хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүд, тухайн байгууллагаас өндөр насын тэтгэвэрт гарсан ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан хүний ар гэрт, мөн өрх толгойлсон эхчүүд, эрчүүд, бүтэн өнчин үлдсэн айлын нэг хүүхдэд үзүүлэх мөнгөн тусlamжийн хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.13 Ажилтан нас барсан тохиолдолд ар гэрт нь олгох буцалтгүй тусlamжийн хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.14 Харьяа аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаад өндөр насын тэтгэвэрт гарсан ахмадууд, YO, МШӨ-ний групптэй хүмүүс нас барсан тохиолдолд олгох буцалтгүй тусlamжийн хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.15 Байгууллагын нэрийн өмнөөс олон улс, улс, хотын чанартай спорт, урлаг, уран сайхны тэмцээн, уралдаанд оролцон амжилт гаргасан ажилтны шагнал урамшууллын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.16 Орон сууцгүй ажилтнуудыг орон сууцтай болгох зорилгоор хөрөнгийн эх үүсвэрийг гаргах, зээлээр орон сууц бариулах, худалдан авахад дэмжлэг үзүүлэх асуудлыг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.17 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад бодит хувь нэмэр оруулсан ажил төрлийн холбоо бүхий аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох ажилтныг шагнах шаагналын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.18 Салбарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр орон тоог цомхгох, ажлын байрыг цөөрүүлэх, хувьчлагдах тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор өмчийн хэлбэр үл харгалзан уг ажилтанд 3-4 жил ажилласан бол 1 ээс 4 сар , 5-10 жил ажилласан бол 6 хүртэл сар ,11-15 жил ажилласан бол 12 хүртэл сар , 16 ба түүнээс дээш жил ажилласан бол 24 хүртэл сарын албан тушаалын болон үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар

- 6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг үлгэр жишээ зохион байгуулсан аж ахуйн нэгж байгууллагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний хорооноос олгодог “Эрүүл аюулгүй байдлыг эрхэмлэгч байгууллага” шагналаар шагнуулахад талууд дэмжлэг үзүүлнэ.
- 6.2 Ажил олгогч ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг бууруулах арга хэмжээг жил бүр авна.
- 6.3 Аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны ISO-45001 стандарт болон нийгмийн хариуцлагын стандартыг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах ажлыг талууд хамтран хэрэгжүүлнэ.

- 6.4 Үйлдвэрлэлийн ослоос болж гэмтэж бэртсэн, нас барсан болон мэргэжлийн өвчин туссан иргэн бүрд зохих хэмжээний тэтгэмж олгогдох нөхцөлийг бүрдүүлж ажилтны эрхийг хамгаалах зорилгоор ажил олгогчийн хариуцлагын албан журмын даатгал, эрсдэлийн үнэлгээнд суурисан даатгалын шинэчлэлийн тогтолцоог бий болгоход талууд хамтран ажиллана.
- 6.5 Жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд үйлдвэрлэлийн ослоор амь эрстсэн хүмүүст хүндэтгэл үзүүлэх ажлыг аж ахуйн нэгж бүр зохион байгуулна.
- 6.6 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулж, орон тооны ажилтан ажиллуулж, үйлдвэрлэлийн явцад гарсан аваар осол гэмтлийг судлан бүртгэх, мэдээлэх, аваар осол гэмтлийг бууруулах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.7 Монгол улсын стандартын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг шинэчлэн тогтоох шаардлагатай ажлын байрны жагсаалтыг хамтран гаргаж Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 6.8 Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 176-р конвенц, ХАБЭА-ын тухай ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 155-р конвенцыг хэрэгжүүлэх ажлыг талууд хамтран зохион байгуулж хэрэгжилтэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Монголын эрчим хүч, геологи уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо хамтран хяналт тавина.

Долоо. Үйлдвэрчний эвлэлийн эрхийг хангах талаар

- 7.1 Ажил олгогч нь үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хууль, Монгол улс соёрхон баталсан ОУХБ-н 135-р конвенцыг хэрэгжүүлэхэд заасан эрхийг хангаж ажиллана Үүнд нь:
- Аж ахуйн нэгж байгууллагын эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны тухай мэдээлэл өгнө.
 - Үйлдвэрчний эвлэлийн хорооны бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн гишүүний татварыг цалингаас бэлэн бусаар хурааж, ҮЭ-ийн хорооны дансанд шилжүүлнэ.
 - Хамтын гэрээ байгуулахдаа хүрсэн түвшингээс нь бууруулахгүй байх зарчим баримтална.
- 7.2 Үйлдвэрчний эвлэл нь дараах үйл ажиллагааг зохион байгуулна.
- Хамтын гэрээ, хэлэлцээр хийх, батлах, явц үр дүнг хэлэлцэх
 - Хамтын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан хичээл, семинар, зөвлөгөөн хийх
 - Үйлдвэрчний байгууллагад тавьсан аливаа санал гомдлыг авч хэлэлцэх
 - Үйлдвэрчний эвлэлийн бүх гишүүдийн хурал хийх
 - Ажил олгогчтой тохиролцсоны дагуу зохион байгуулах бусад арга хэмжээнүүд
- 7.3 Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульт ажилтныг хамтын гэрээнд хамруулан жилийн болон сар, улирлын ажлын үр дүнгийн шагнал олгох бөгөөд олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа хүмүүсийг төр засгийн шагналд тодорхойлж болно.
- 7.4 Салбарын хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор бүтээгдэхүүний үнэ тарифыг нэмэгдүүлэх, хууль эрх зүй, бизнесийн орчныг сайжруулахад салбарын ҮЭ-ийн холбоо, ҮЭ-ийн хороод дэмжлэг үзүүлж ажиллана.



Найм. Хэлэлцээрийн хэрэгжилтийн талаар

- 8.1 Хэлэлцээр нь талуудын гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн 2 жилийн хугацаанд хүчинтэй. Хэлэлцээрт талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө шинэ хэлэлцээр байгуулаагүй, эсвэл нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол талууд энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөнө.
- 8.2 Салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийн биелэлтийн явцыг жил бүр дүгнэж хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 8.3 Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, өмчлөлийн харьялалд өөрчлөлт орох нь энэхүү хамтын хэлэлцээрээр тохирсон асуудлыг цуцлах үндэслэл болохгүй.
- 8.4 Хэлэлцээрээр хүлээсэн үүрэг зөрчигдсөн тохиолдолд аль нэг тал маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд төлөөлөгчдийн хуралдааныг 7 хоногийн дотор зарлан хуралдуулах эрхтэй.
- 8.5 Хэлэлцээрээр харилцан хүлээсэн үүргээ биелүүлэх явцад талуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс саад учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 8.6 Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн маргааныг “Хөдөлмөрийн тухай хууль” болон бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.



БАТАЛГААЖИЛТ:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг төлөөлж:

- 1 Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал
- 2 Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Батбаяр
- 3 Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Д.Дамба
- 4 Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Г.Мөнгөнзүл
- 5 Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн хэлтсийн шинжээч Т.Мөнхбаяр
- 6 Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн М.Анхбаяр



Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоог төлөөлж:

- 1 МЭХГҮҮҮЭ-ийн холбооны дарга Х.Буянжаргал
“Монголпросцетмет” ТӨҮГ-ийн
хорооны дарга Д.Батболд
- 2 “Багануур” ХК-ийн
ҮЭ-ийн хорооны дарга О.Бат-Ирээдүй
- 3 ҮЭ-ийн хорооны дарга Л.Мөнхтуяа
“Геологийн судалгааны төв” ТӨҮГ-н ҮЭ-ийн
хорооны дарга Н.Элдэв-Очир
- 4 “Эрдэнэс таван толгой” ХК Ажиллагсдын ҮЭ-
ийн хорооны дарга Ц.Сувдгэрэл
- 5 ҮЭ-ийн хорооны дарга
“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-ийн
- 6 ҮЭ-ийн хорооны дарга



Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын
ажил олгогч, эздийг төлөөлж:

- 1 Монголын уул уурхайн үндэсний Т.Гантэмэр
ассоциацийн ерөнхийлөгч
- 2 Монголын үйлдвэрлэлийн геологичдын М.Очирбат
холбооны ерөнхийлөгч
- 3 Монгол нүүрс ассоциацийн Ж.Золжаргал
гүйцэтгэх захирал
- 4 Монголын уул уурхайн Д.Энхболд
ассоциацийн гүйцэтгэх захирал
- 5 Монголын үйлдвэрлэлийн геологичдын Д.Хашбат- 2
холбооны гүйцэтгэх захирал
- 6 Монгол нүүрс ассоциацийн Б.Эрдэнэцэцэг
ажлын албаны менежер



БАТАЛГААЖИЛТ:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг төлөөлж:

- 1 Төрийн нарийн бичгийн дарга
- 2 Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
- 3 Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч
- 4 Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч
- 5 Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн хэлтсийн шинжээч
- 6 Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн



Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоог төлөөлж:

- 1 МЭХГҮҮҮЭ-ийн холбооны дарга
“Монголпросцетмет” ТӨҮГ-ийн хорооны дарга
- 2 “Багануур” ХК-ийн
- 3 ҮЭ-ийн хорооны дарга
- 4 “Геологийн судалгааны төв” ТӨҮГ-н ҮЭ-ийн хорооны дарга
- 5 “Эрдэнэс таван толгой” ХК Ажиллагсдын ҮЭ-ийн хорооны дарга
- 6 ҮЭ-ийн хорооны дарга



Х.Буянжаргал
Д.Батболд
О.Бат-Ирээдүй
Л.Мөнхтуяа
Н.Элдэв-Очир
Ц.Сувдгэрэл

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ажил олгогч, эздийг төлөөлж:

- 1 Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч
- 2 Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбооны ерөнхийлөгч
- 3 Монгол нүүрс ассоциацийн гүйцэтгэх захирал
- 4 Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал
- 5 Монголын үйлдвэрлэлийн геологийн холбооны гүйцэтгэх захирал
- 6 Монгол нүүрс ассоциацийн ажлын албаны менежер



Т.Гантөмөр
М.Очирбат
Ж.Золжаргал
Д.Энхболд
Д.Хашбат- 2
Б.Эрдэнэцэцэг

